

Аймгийн Аудитын газар

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Цагааннуур тосгоны ТТЗ-ийн
2016 оны 12 дугаар сарын 31-нээр
дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан

Аудитын код: БӨА-2017/1/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: 0

Тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 99417382 Цахим хаяг: mhkuangan@yahoo.com

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930, 99932710 Цахим хаяг: kh_jenisbek@yahoo.com

Аудитор: Н6Вgygjuol 95429524

Утас: Цахим хаяг:

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.10	Дараагийн аудитаар авч үзэхбуюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	Error! Bookmark not defined.
2.12	Шилэн дансны мэдээлэл	Error! Bookmark not defined.
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	Error! Bookmark not defined.
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	Error! Bookmark not defined.
3	Менежментийн захидал	18
3.1	«management_zurchil1»	Error! Bookmark not defined.
3.2	«management_zurchil2»	Error! Bookmark not defined.
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	20
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	20
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	21
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..	Error! Bookmark not defined.
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	24
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	27

1 Аудитын гэрчилгээ



ЦАГААННУУР ТОСГОНЫ ЗАХИРАГЧ
Д.ЕСБОЛАТ ТАНАА

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 70422954, 70422930
E-mail: bayanulgi@audit.gov.mn

тантай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон, аккрузал сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу аймгийн аймгийн Аудитын газраас аудит хийв.

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Sanal dugnelt-TSnuur TTZ 1.doc

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь Оршин байх, Тохiolдсон байх, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

1. ОНХСангийн 2016 оны батлагдсан төсөвт аймгийн ОНХСангаас дутуу олгосон 7.3 сая төгрөгийн орлогын шилжүүлэгийг санхүүгийн тайланд санхүүжилтийн авлагаар тусгаж харуулаагүй, ОНХСангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний дутуу олгогдсон 6,5 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийн өглөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй,
2. Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө, цэвэр хөрөнгө/өмчийн эхний, эцсийн үлдэгдлийн нийт дүнг зөрүүтэй тайлагнасан, Мөнгөн гүйлгээний тайлан, Үр дүнгийн тайланд орлого, зардлын дүнг илүү, дутуу илэрхийлсэн, Өмчийн өөрчлөлтийн тайланд хуримтлагдсан болон тайланд үеийн үр дүнг зөрүүтэй тусгасан, Төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөө, гүйцэтгэлийг зөрүүтэй тусгасан зэргээр санхүүгийн тайланг нийтдээ 452,6 сая төгрөгийн алдаа зөрүүтэй гаргаж ирүүлсэнийг залруулга хийлээ.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээр дурьдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн байдлын, санхүүгийн үр дүнгийн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйлгээний тайлангууд нь УСНББОУС, Сангийн сайдын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой журам зааврын дагуу материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Цагааннуур тосгоны Захирагч Д.Есболат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасаншийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.2 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Цагааннуур тосгоны Захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цагааннуур тосгоны Захирагчийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.03.20-ноос 2017.03.25-ны хооронд хийж, аудитын тайланг 2017.03.27-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Аймгийн аудитын газрын Аудитор Х.Манаргүл хариуцаж хэрэгжүүлэв.

Цагааннуур тосгоны Захирагч 2016 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017.03.09-нд төрийн аудитын байгууллагад 2017.03.09-ны өдрийн 46–р албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Цагааннуур тосгоны Захирагч *"Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн Хуралд оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, харьяалах нутаг дэвсгэрийнх нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төрийн эрх бүхий байгууллагаас батлах төсөл, хөтөлбөрт санал өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, харьяалах нутаг дэвсгэрийнхээ санхүүгийн байдал, хүн амын орлого, хөдөлмөрийн нөөц, газрын төлөв байдлын удирдлага, төлөвлөлтийг хангахад шаардагдах тайлан тэнцэл гаргах,*

-харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрт заасан тайлан мэдээг хугацаанд нь хариуцан гаргуулж, хяналт тавих, хүн ам, орон сууц, газар, мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого явуулах ажлыг зохион байгуулах, нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж байна.

Цагааннуур тосгоны Захирагчийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Цагааннуур тосгоны Захирагчийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын

Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Цагааннуур тосгоны ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Цагааннуур тосгоны Захирагчийн санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн "Пластик" програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Цагааннуур тосгоны Захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 19 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 5 асуудал эрсдэл өндөр, 5 асуудал эрсдэл дунд 5 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 15 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 3 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих-шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь эрсдэлийн үнэлгээний түвшинтэй холбоотой юм.

Цагааннуур тосгоны Захирагчийн 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1074,3 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 21,5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горимсорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэлтүс бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 4 чиглэлээр 6 эрсдэлтэй асуудалд 18 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 100 хувь буюу 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Аудитаар илэрсэн алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийлэлээс аудитын явцад залруулах боломжтой бүртгэл тайлагналтай холбоотой нийдээ 452,7 сая төгрөгийн алдаа зөрчилтэй холбоотой асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	1	0	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	1	0	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав. Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитаар илэрсэн доор тэмдэглэсэн алдаа зөрчлийг санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

1.ОНХСангийн 2016 оны батлагдсан төсөвт аймгийн ОНХСангийн төсвөөс дутуу олгосон 7,3 сая төгрөгийн орлогын шилжүүлэгийг санхүүгийн тайланд санхүүжилтийн авлагаар тусгаж харуулаагүй, мөн ОНХСангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний дутуу олгосон 6,5 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийн өглөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй,

2.Санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдлийг 4,5 сая төгрөгөөр, эцсийн үлдэгдлийг 4,0 сая төгрөгөөр, Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд програм хангамжийн эхний үлдэгдлийг 0,6 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан,

3.Үр дүнгийн тайланд өмнөх оны орлогын дүнг 113,5 сая төгрөгөөр илүү, тайлант оны орлогын дүнг 6906.1 сая төгрөгөөр дутуу тусгасан,

4.Мөнгөн гүйлгээний тайланд өмнөх оны орлогын дүнг 112,9 сая төгрөгөөр, тайлант оны орлогын дүнг 4,0 сая төгрөгөөр илүү, өмнөх оны нийт цэвэр мөнгөн гүйлгээг 24,5 сая төгрөгөөр дутуу, тайлант оны нийт цэвэр мөнгөн гүйлгээг 4,0 сая төгрөгөөр илүү, Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал хэсэгт худалдан авсан үндсэн хөрөнгийг дүнг 52,2 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан,

5.Өмчийн өөрчлөлтийн тайлан өмнөх оны үр дүнг 10,7 сая төгрөгөөр, тайлант оны үр дүнг 0,2 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан,

6.Төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөөг 0,3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийг 100,6 сая төгрөгөөр илүү тусгаж санхүүгийн нэгтгэсэн тайланг нийтдээ 452,7 сая төгрөгийн алдаатай гаргаж Төсвийн тухай хуулийн 26.1 "Төсвийн байгууллага нь НББОУС болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтлөнө" 16.5.7-д заасан "Байгууллагын санхүүгийн болон бусад тайлан мэдээг үнэн зөв гаргах", Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан "Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар албан шаардлага өгөгдөөгүй байна

2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитаар алдаа зөрчил гаргасан холбогдох албан тушаалтануудад сахилгын шийтгэл ноогдуулах санал хүргүүлсэн

2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх алдаа, зөрчилтэй асуудал байхгүй байна.

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХБУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

- 1.ОНХСан болон СХСангийн авлага, өглөгийн баталгаажуулалт хийж байх
2. Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд, үнэн зөв гаргаж ирүүлж байх

1. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3996946.21	2284593.21	-1712353.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	3996946.21	2284593.21	-1712353.00
3121	Төгрөг	3996946.21	2284593.21	-1712353.00
31211	Төрийн сангийн харилцах	3975843.21	2263990.21	-1711853.00
31213	Арилжааны банк дахь харилцах	21103.00	20603.00	-500.00

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар оны эцэст нийтдээ 2,3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарч оны эхнээс 1,7 сая төгрөгөөр буурсан байна. Мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл нийт үлдэгдэл мөнгөний 2,3 сая төгрөг нь төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл байна. Харилцах дансны үлдэгдлийн 0,8 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангийн, 1,5 сая төгрөг нь орон нутгийн орлогын дансны үлдэгдэл байна.

2. Авлагын бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
33	АВЛАГА	7040000.00	11368991.00	4328991.00

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2547000.00	87991.00	-2459009.00
335	Бусад авлага	4493000.00	11281000.00	6788000.00
3351	Байгууллагаас авах авлага	0.00	7300000.00	7300000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	4,493,000.00	3981000.00	-512000.00

Авлагын үлдэгдэл өмнөх оноос 61,4 хувь буюу 4,3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Авлагын 64,6 хувь буюу 7,3 сая төгрөг нь татаас санхүүжилтийн авлага, 0,3 хувь буюу 0,09 сая төгрөг нь ажилчидтай холбогдсон авлага, 35,1 хувь буюу 4,0 сая төгрөг Сум хөгжүүлэх сангийн зээлийн болон хүүгийн авлага байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг өмнөх оны үлдэгдэлтэй харьцуулахад 11,3 хувь буюу 0,5 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд хүүгийн орлогоос 500,0 мянган төгрөг, үндсэн зээлийн эргэн төлөлтөөс 12,0 мянган төгрөг оруулж, харин зээл олгоогүй байна.

ОНХСангийн 2016 оны батлагдсан төсвөөс 7,3 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан боловч санхүүгийн тайланд авлагаар харуулаагүй байсныг залруулга хийж авлагаар тусгуулж залруулга хийсэн.

3. Бараа материалын бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
35	БАРАА МАТЕРИАЛ	53099604.70	62723779.08	9624174.38
351	Түүхий эд материал	13130112.52	11698857.52	-1431255.00
354	Хангамжийн материал	33906392.18	44961821.56	11055429.38

Бараа материалын үлдэгдэл оны эхнээс 18,1 хувиар буюу 9,6 сая төгрөгөөр өссөн байна.Тайлант оны эхэнд 53,1 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан ба 123,8 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 3,3 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч бүгд 127,2 сая төгрөгийн бараа материалыг орлого авч данс бүртгэлд тусган, 117,5 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж жилийн эцэст 62,7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Тайлант онд тусгай зориулалттай материал, бичиг хэргийн материал, аж ахуйн материал, түлш, шатах тослох материал, түлш, шатах тослох материал, хүнсний материал,бусад хангамжийн материал 0,1-11,0 сая төгрөгөөр өссөн бол Эм боох материал, Барилгын засварын материал 0,1-4,0 сая төрөгөөр тус тус буурсан байна.

Түлш, шатах тослох материал, хүнсний материал, бусад хангамжийн материалууд өссөн дүнтэй гарч байгаа нь төсөвт байгууллагууд оны эцэст хүнс, түлш шатахуун хангамжийн материалыг нөөцөлсөнтэй холбоотой байна.

4. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1102858221.00	1069787846.24	-33070374.76
392	Биет хөрөнгө	1101934887.46	1069325845.93	-32609041.53
393	Биет бус хөрөнгө	923333.54	462000.31	-461333.23

Тайлант онд 4,4 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 29,0 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, 0,3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хасагдаж, үндсэн хөрөнгийн үлдэгдэл оны эхнээс 33,1 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна. Тайлант онд 0,3 сая төгрөгийн тавилга эд хогшил актлагдсан байна

Төсөвт байгууллагууд нийтдээ 29,0 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээж авсан ба задалж авч үзвэл Захирагчийн алба 1,3 сая төгрөгийн, Дунд сургууль 21,6 сая төгрөгийн, ЭМТөв 6,1 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

5. Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>6905594.21</u>	<u>6695500.00</u>	<u>-210094.21</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6905594.21	6695500.00	-210094.21
413	Өглөг	6905594.21	6695500.00	-210094.21
4136	Бусад өглөг	6905594.21	6695500.00	-210094.21
41361	Байгууллагад төлөх өглөг	3472493.21	6500000.00	3027506.79
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	195500.00	195500.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	3433101.00	0.00	-3433101.00

Өр төлбөрийн үлдэгдэл оны эхнээс 2,9 хувь буюу 0,21 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна. Оны эхэнд, Захирагчийн алба 3,5 сая төгрөгийн, ЭМТөв 3,4 сая төгрөгийн бүгд 6,9 сая төгрөгийн өглөгтэй байсан бол оны эцэст Хүүхдийн цэцэрлэг 0,2 сая төгрөгийн өглөгтэй гарч оны эхнээс 6,7 сая төгрөгөөр буурсан байна.

Цагааннуур тосгоны ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар ОНХСангийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний дутуу олгогдсон 6,5 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийн өглөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй орхигдуулсаныг аудитын явцад санхүүгийн тайланд тусгуулан залруулга хийлээ. ОНХСангийн 6,5 сая төгрөгийн өглөгтэй байна.

6. Орлого, татаас санхүүжилтийн талаар

6.1 Улсын төсвийн санхүүжилт

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангаар тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр 832,4 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөгдснөөс, гүйцэтгэлээр 826,3 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаандаа зарцуулж, 6,1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

6.2 Орон нутгийн төсвийн санхүүжилт

Орон нутгийн захиргааны байгууллагуудад 97,3 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 88,8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, орон нутгийн татварын орлогоос 8,4 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн санхүүжүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтээр 25,4 сая төгрөг хүлээн авчээ.

6.3 Өөрийн орлого

Цагааннуур тосгоны төсөвт байгууллагуудад үйл ажиллагааны орлогоос 650,0 мянган төгрөгийн орлого оруулах төлөвлөгөө өгөгдсөнөөс 650,0 мянган төгрөгийн орлого оруулан төлөвлөгөөг 100 хувь биелүүлсэн байна.

6.4 Татварын орлого

Ногооннуур сумын ИТХ-аас хуралдааны тогтоолоор орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 4,9 сая төгрөгөөр баталсан байна. Орлогын бүтцийг авч үзвэл нийт орлогын 60,0 хувийг ХАОАТатвараас, 20,0 хувийг бусад татвараас, 20,0 хувийг өмчийн татвараас оруулахаар төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А.Урсгал орлого	4,964,600.00	6,392,747.00	1,428,147.00	128.8
І.Татварын орлого	4,964,600.00	6,367,747.00	1,403,147.00	128
1.Орлогын албан татвар	3,000,000.00	4,231,717.00	1,231,717.00	141
1.1 ХАОАТатвар	3,000,000.00	4,231,717.00	1,231,717.00	141.1
Үйл ажиллагааны орлого	3,000,000.00	4,231,717.00	1,231,717.00	141.1
2.Өмчийн татвар	964,600.00	978,500.00	13,900.00	101.4
Бууны албан татвар	964,600.00	978,500.00	13,900.00	101.4
4.Бусад татвар	1,000,000.00	1,157,530.00	157,530.00	115.8
Улсын тэмдэгтийн хураамж	1,000,000.00	1,157,530.00	157,530.00	115.8
ІІ.Татварын бус орлого	-	25,000.00	25,000.00	
2.2 Хүү, торгуулийн орлого		25,000.00	25000	

Гүйцэтгэлээр 4 төрлийн татварын орлогоос 6,4 сая төгрөгийн орлого оруулан төлөвлөгөөг 28,8 хувиар буюу 1,4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Нийт орлогын 65,6 хувийг ХАОАТатвараас, 18,8 хувийг бусад татвараас, 15,3 хувийг өмчийн татвараас, 0,3 татварын бус орлого бүрдүүлж байна.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд ХАОАТатвар 41,1 хувиар буюу 1231,7 мянган төгрөгөөр, бусад татвар 15,8 хувиар буюу 157,5 мянган төгрөгөөр, өмчийн татвар 13,9 хувиар буюу 1,3 мянган төгрөгөөр давж биелэгдсэн байна.Хүү торгуулийн орлогоос 25,0 мянган төгрөг оруулсан байна.

Сумын төрийн сан дахь цалин хөлсний татварын орлогын 901 тоот дансаар 238,6 сая төгрөгийн орлогыг оруулж аймгийн төсөвт төвлөрүүлж Сумын төсөвт байгууллагуудаас төлсөн цалин хөлсний татварын орлогыг тухай бүр аймгийн ЦХТОрлогын дансанд төвлөрүүлж ажилласан байна.

Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 6,4 сая төгрөгийн орлого оруулсан. Оны эхэнд орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 3,5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба оны эцэст 1,5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч үлдэгдэл оны эхнээс 2,0 сая төгрөгөөр буурсан байна.

6.5 Бусад

Тайланд онд ОНХСангийн санхүүжилтэнд 53,6 сая төгрөгийн санхүүжилт авч, 53,6 сая төгрөгийг зарцуулж оны эцэст үлдэгдэлгүй гарсан байна. Сум хөгжүүлэх сан оны эхэнд 495,8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба хүү болон зээлийн эргэн төлөлтөөс 512,0 мянган төгрөгийг орлого оруулан, 247,0 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулж оны эцэст 1,9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

7. Зарлага санхүүжилтийн талаар

7.1 Санхүүжилтийн зарцуулалт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Цагааннуур тосгоны ТТЗ-ийн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой төсөвт байгууллагуудын хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2016 оны урсгал зардалд нийтдээ 991,2 сая төгрөгийн төсөв батлагдсаны 832,4 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 97,3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 60,9 сая төгрөгийг ОНХСангийн хөрөнгөөр, 0,6 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 826,3 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 8,4 сая төгрөгийн санхүүжилт, ОНХСангийн орлогын шилжүүлэгээр 53,6 сая төгрөгийн, санхүүгийн дэмжлэгээс 88,8 сая төгрөгийн санхүүжилтийг авч, өөрийн үйл ажиллагааны орлогоос 0,6 сая төгрөг оруулан бүгд дүнгээр 977,7 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр ажиллаж, батлагдсан төсвөөс нийт дүнгээр 13,5 сая төгрөгөөр бага зарлага гаргажээ.

Энэ нь ОНХСанд төсвөөс олгох санхүүжилт 7,3 сая төгрөгөөр дутуу олгогдсон болон төсөвт байгууллагуудаас зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	991,206,400.00	977,723,459.80	(13,482,940.20)	98.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	991,206,400.00	977,723,459.80	(13,482,940.20)	98.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	945,427,600.00	932,913,059.80	(12,514,540.20)	98.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл	640,902,900.00	640,902,900.00	-	100.00

Цагааннуур тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

	урамшил				
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,499,100.00	70,499,100.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,918,300.00	59,773,712.00	(144,588.00)	99.76
2104	Хангамж, бараа материалын зардал	20,844,265.00	20,901,165.00	56,900.00	100.27
2105	Нормативт зардал	64,685,800.00	60,474,031.80	(4,211,768.20)	93.49
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,098,500.00	4,031,100.00	(67,400.00)	98.36
2107	Томилолт, зочны зардал	3,340,900.00	3,354,100.00	13,200.00	100.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	73,223,600.00	65,922,800.00	(7,300,800.00)	#DIV/0!
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,914,235.00	7,054,151.00	(860,084.00)	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,778,800.00	44,810,400.00	(968,400.00)	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,778,800.00	44,810,400.00	(968,400.00)	100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,078,000.00	11,109,600.00	(968,400.00)	89.13
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,235,200.00	19,235,200.00	-	97.88
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,763,100.00	13,763,100.00	-	97.88
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	702,500.00	702,500.00	-	91.98
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	991,206,400.00	977,723,459.80	(13,482,940.20)	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	893,275,600.00	879,860,159.80	(13,415,440.20)	100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	832,375,600.00	826,260,159.80	(6,115,440.20)	100.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	60,900,000.00	53,600,000.00	(7,300,000.00)	98.64
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	97,280,800.00	97,213,300.00	(67,500.00)	98.50
132001	Орон нутгийн төсвөөс	97,280,800.00	97,213,300.00	(67,500.00)	99.27
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	650,000.00	650,000.00	-	88.01
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	650,000.00	650,000.00	-	99.93
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-	99.93
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			-	100.00

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар авч үзвэл: байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, нормативт зардал, бараа үйлчилгээний бусад зардал, бусад урсгал шилжүүлгийн зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардал, эд хогшил, урсгал засварын зардлуудыг 0,07-7,3 сая

төгрөгөөр хэмнэж, хангамж, бараа материалын зардал, томилолтын зардлуудыг 0,01-0,07 сая төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийг байгууллага бүрээр харуулбал:

/төгрөг/

Төсөвт байгууллагуудын нэр	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
